

Gesetz
zu dem Vertrag vom 26. Juni 1991
zwischen der Bundesrepublik Deutschland
und der Mongolischen Volksrepublik
über die Förderung und den gegenseitigen Schutz
von Kapitalanlagen

Vom 19. Januar 1996

Der Bundestag hat mit Zustimmung des Bundesrates das folgende Gesetz beschlossen:

Artikel 1

Dem in Bonn am 26. Juni 1991 unterzeichneten Vertrag zwischen der Bundesrepublik Deutschland und der Mongolischen Volksrepublik über die Förderung und den gegenseitigen Schutz von Kapitalanlagen sowie dem dazugehörigen Protokoll wird zugestimmt. Der Vertrag und das Protokoll werden nachstehend veröffentlicht.

Artikel 2

- (1) Dieses Gesetz tritt am Tage nach seiner Verkündung in Kraft.
(2) Der Tag, an dem der Vertrag nach seinem Artikel 13 Abs. 2 und das Protokoll in Kraft treten, ist im Bundesgesetzblatt bekanntzugeben.

Das vorstehende Gesetz wird hiermit ausgefertigt und wird im Bundesgesetzblatt verkündet.

Berlin, den 19. Januar 1996

Der Bundespräsident
Roman Herzog

Der Bundeskanzler
Dr. Helmut Kohl

Der Bundesminister für Wirtschaft
Rexrodt

Der Bundesminister des Auswärtigen
Kinkel

**Vertrag
zwischen der Bundesrepublik Deutschland
und der Mongolischen Volksrepublik
über die Förderung und den gegenseitigen Schutz von Kapitalanlagen**

**Холбооны Бүгд Найрамдах Герман улс,
Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Хоорондын Хөрөнгө Оруулалтыг
Хөхүүлэн Дэмжих, Харилцан Хамгаалах Тухай Гэрээ**

Die Bundesrepublik Deutschland
und
die Mongolische Volksrepublik,
im folgenden Vertragsparteien genannt, –

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ба
Бүгд Найрамдах Монгол Ард Улс
(цаашид Хэлэлцэн тохирогч Талууд гэх)

in dem Wunsch, die wirtschaftliche Zusammenarbeit zwischen beiden Staaten zu vertiefen,

in dem Bestreben, günstige Bedingungen für Kapitalanlagen von Staatsangehörigen oder Gesellschaften des einen Staates im Hoheitsgebiet des anderen Staates zu schaffen,

in der Erkenntnis, daß eine Förderung und ein vertraglicher Schutz dieser Kapitalanlagen geeignet sind, die private wirtschaftliche Initiative zu beleben und den Wohlstand beider Völker zu mehren –

haben folgendes vereinbart:

Artikel 1

Für die Zwecke dieses Vertrags

1. umfaßt der Begriff „Kapitalanlagen“ Vermögenswerte jeder Art, insbesondere
 - a) Eigentum an beweglichen und unbeweglichen Sachen sowie sonstige dingliche Rechte wie Hypotheken und Pfandrechte;
 - b) Anteilsrechte an Gesellschaften und andere Arten von Beteiligungen an Gesellschaften;
 - c) Ansprüche auf Geld, das verwendet wurde, um einen wirtschaftlichen Wert zu schaffen, oder Ansprüche auf Leistungen, die einen wirtschaftlichen Wert haben;
 - d) Rechte des geistigen Eigentums, wie insbesondere Urheberrechte, Patente, Gebrauchsmuster, gewerbliche Muster und Modelle, Marken, Handelsnamen, Betriebs- und Geschäftsgeheimnisse, technische Verfahren, Know-how und Goodwill;
 - e) öffentlich-rechtliche Konzessionen einschließlich Aufsuchungs- und Gewinnungskonzessionen im Zusammenhang mit natürlichen Ressourcen.

Eine Änderung der Form, in der Vermögenswerte angelegt werden, läßt ihre Eigenschaft als Kapitalanlage unberührt;

2. bezeichnet der Begriff „Erträge“ diejenigen Beträge, die auf eine Kapitalanlage für einen bestimmten Zeitraum anfallen, wie Gewinnanteile, Dividenden, Zinsen, Lizenz- oder andere Entgelte;
3. bezeichnet der Begriff „Staatsangehörige“
 - a) in bezug auf die Bundesrepublik Deutschland: Deutsche im Sinne des Grundgesetzes für die Bundesrepublik Deutschland,

хоёр улсын хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхийг хүсч,

аль аль улсын иргэд болон компаниас нөгөө улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулахад тааламжтай нөхцөл бүрдүүлэхийг эрмэлзэн,

ийнхүү хөрөнгө оруулалт хийх явдлыг хөхүүлэн дэмжих, гэрээгээр хамгаалах нь хувийн салбарт ажил хэргийн санаачилгыг идэвхжүүлэх, улмаар хоёр орны ард түмний аж байдлыг дээшлүүлэх болно гэдгийг хүлээн зөвшөөрч,

дорхи зүйлийг хэлэлцэн тохиров.

Нэгдүгээр зүйл

Энэхүү Гэрээний:

- 1) „хөрөнгө оруулалт“ гэсэн нэр томъёогоор бүх төрлийн үнэ өртөг бүхий зүйл, ялангуяа
 - a) хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө, тэрчлэн эд хөрөнгийн дэнчин, барьцаа зэрэг өмчийн бусад аль ч эрх,
 - b) компаний хувьцаа болон компаний талаарх ашиг сонирхлын бусад хэлбэр,
 - v) эдийн засгийн өртөг үүсгэхэд зарцуулсан мөнгө болон эдийн засгийн өртөг бүхий аль ч ажил үүргийн биелэлтийг шаардах эрх,
 - г) зохиогчийн эрх, патент, хэрэглээний болон сурталчилгааны загварууд, барааны тэмдэг, пүүсийн нэр, пүүсийн болон ажил хэргийн нууц, техникийн ажиллабар, ноу-хау, пүүсийн нэр хүнд зэрэг оюуны өмчийн эрхүүд,
 - д) хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл (концесс), тухайлбал байгалийн баялгийг эрж хайх, боловсруулах, ашиглах зөвшөөрлийг хэлнэ.
- Хөрөнгө оруулсан үнэ өртөг бүхий зүйлийн хэлбэрийн өөрчлөлт тэдгээрээс хөрөнгө оруулалт гэсэн ангилалд багтах явдалд үл нөлөөлнө;
- 2) „өгөөж“ гэдгээр ашиг, ногдол ашиг, хүү, шан харамж буюу шагнал зэрэг тодорхой хугацаанд хөрөнгө оруулалтын үр дүнд олсон орлогыг нэрлэнэ;
 - 3) „иргэн“ гэсэн нэр томъёогоор
 - a) Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хувьд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хуульд тодорхойлон заасан германчуудыг хэлнэ,

- b) in bezug auf die Mongolische Volksrepublik:
Mongolen im Sinne der Verfassung der Mongolischen Volksrepublik;
4. bezeichnet der Begriff „Gesellschaften“
- a) in bezug auf die Bundesrepublik Deutschland:
jede juristische Person sowie jede Handelsgesellschaft oder sonstige Gesellschaft oder Vereinigung mit oder ohne Rechtspersönlichkeit, die ihren Sitz in der Bundesrepublik Deutschland hat, gleichviel, ob ihre Tätigkeit auf Gewinn gerichtet ist oder nicht,
- b) in bezug auf die Mongolische Volksrepublik:
jede wirtschaftliche Vereinigung, die nach den Gesetzen der Mongolischen Volksrepublik gegründet worden ist und ihren Sitz in der Mongolischen Volksrepublik hat.

Artikel 2

(1) Jede Vertragspartei wird in ihrem Hoheitsgebiet Kapitalanlagen von Staatsangehörigen oder Gesellschaften der anderen Vertragspartei nach Möglichkeit fördern und diese Kapitalanlagen in Übereinstimmung mit ihren Rechtsvorschriften zulassen. Sie wird Kapitalanlagen in jedem Fall gerecht und billig behandeln.

(2) Eine Vertragspartei wird die Verwaltung, die Verwendung, den Gebrauch oder die Nutzung der Kapitalanlagen von Staatsangehörigen oder Gesellschaften der anderen Vertragspartei in ihrem Hoheitsgebiet in keiner Weise durch willkürliche oder diskriminierende Maßnahmen beeinträchtigen.

(3) Kapitalanlagen von Staatsangehörigen oder Gesellschaften der einen Vertragspartei, die in Übereinstimmung mit den Rechtsvorschriften der anderen Vertragspartei in ihrem Hoheitsgebiet zugelassen sind, genießen den vollen Schutz dieses Vertrags.

Artikel 3

(1) Jede Vertragspartei behandelt Kapitalanlagen in ihrem Hoheitsgebiet, die im Eigentum oder unter dem Einfluß von Staatsangehörigen oder Gesellschaften der anderen Vertragspartei stehen, sowie Staatsangehörige oder Gesellschaften der anderen Vertragspartei hinsichtlich ihrer Betätigung im Zusammenhang mit Kapitalanlagen in ihrem Hoheitsgebiet nicht weniger günstig als Kapitalanlagen der eigenen Staatsangehörigen und Gesellschaften oder Kapitalanlagen von Staatsangehörigen und Gesellschaften dritter Staaten.

(2) Die in Absatz 1 genannte Behandlung bezieht sich nicht auf Vorrechte, die eine Vertragspartei den Staatsangehörigen oder Gesellschaften dritter Staaten wegen ihrer Mitgliedschaft in einer Zoll- oder Wirtschaftsunion, einem gemeinsamen Markt oder einer Freihandelszone oder wegen ihrer Assoziierung damit einräumt.

(3) Die in diesem Artikel gewährte Behandlung bezieht sich nicht auf Vorteile, die eine Vertragspartei den Staatsangehörigen oder Gesellschaften dritter Staaten aufgrund eines Doppelbesteuerungsabkommens oder sonstiger Vereinbarungen über Steuerfragen gewährt.

Artikel 4

(1) Kapitalanlagen von Staatsangehörigen oder Gesellschaften einer Vertragspartei genießen im Hoheitsgebiet der anderen Vertragspartei vollen Schutz und volle Sicherheit.

(2) Kapitalanlagen von Staatsangehörigen oder Gesellschaften einer Vertragspartei dürfen im Hoheitsgebiet der anderen Vertragspartei nur zum allgemeinen Wohl und gegen Entschädigung enteignet, verstaatlicht oder anderen Maßnahmen unterworfen werden, die in ihren Auswirkungen einer Enteignung oder Verstaatlichung gleichkommen. Die Entschädigung muß dem Wert der enteigneten Kapitalanlage unmittelbar vor dem Zeitpunkt entsprechen, in dem die tatsächliche oder drohende Enteignung, Verstaatlichung oder vergleichbare Maßnahme öffentlich bekannt wurde. Die Entschädigung muß unverzüglich geleistet werden und ist bis zum Zeitpunkt der vollständigen Zahlung mit dem üblichen bankmäßigen Zinssatz zu verzinsen; sie muß tatsächlich

b) Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хувьд Үндсэн хуульд дурдсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын иргэдийг хэлнэ;

4) „компани“ гэсэн нэр томъёогоор

a) Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хувьд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын нутаг дэвсгэрт оршдог хуулийн аль ч этгээд, тэрчлэн хууль зүйн шинжтэй эсхүл хууль зүйн шинжгүй арилжааны буюу бусад аль ч компани эсвэл нэгдлүүдийг,

b) Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хувьд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын нутаг дэвсгэрт оршдог, түүний хууль тогтоомжийн дагуу байгуулсан аж ахуйн нэгжүүдийг хэлнэ. Тэдгээрийн үйл ажиллагаа ашиг олох зорилгыг агуулсан буюу агуулаагүй байж болно.

Хоёрдугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч Тал бүр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэд буюу компаниас түүний нутаг дэвсгэрт хөрөнгө оруулалт хийх явдлыг аль болох хөхүүлэн дэмжиж, ийнхүү оруулж буй хөрөнгийг хууль тогтоомжийнхоо дагуу хүлээн зөвшөөрнө. Ийнхүү хийж буй хөрөнгө оруулалтад аль ч тохиолдолд шударга, эрх тэгш хандана.

2. Хэлэлцэн тохирогч аль аль Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэд буюу компаниас түүний нутаг дэвсгэрт оруулсан хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахад нь үндэслэлгүй саад тотгор учруулж, ялгаварлан гадуурхахгүй.

3. Хэлэлцэн тохирогч аль аль Талын нутаг дэвсгэрт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэд буюу компаниас түүний хууль тогтоомжийн дагуу хийхийг зөвшөөрсөн хөрөнгө оруулалт нь энэхүү Гэрээний бүрэн хамгаалалтад байна.

Гуравдугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч аль аль Тал түүний нутаг дэвсгэрт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэд буюу компаний эзэмшдэг эсвэл хяналт тавьдаг хөрөнгө оруулалт, түүнчлэн хөрөнгө оруулалттай холбогдсон үйл ажиллагаа явуулахад нь өөрийн эсхүл гуравдагч аль ч улсын иргэд буюу компаний хөрөнгө оруулалт, түүнчлэн хөрөнгө оруулалттай холбогдсон үйл ажиллагаа явуулахад нь олгодгоосоо дутуугүй тааламжтай нөхцөл олгоно.

2. 1 дэх заалтад дурдсан нөхцөл нь Хэлэлцэн тохирогч аль аль Талаас гишүүнээр нь элссэн эсвэл хамтарч ажилладаг гаалийн буюу эдийн засгийн холбоо, нэгдсэн зах зээл эсхүл чөлөөт худалдааны бүсийн гишүүн бусад улсын иргэд буюу компанид олгодог давуу талд хамаарахгүй.

3. Энэ зүйлийн дагуу олгосон нөхцөл нь давхар татвараас чөлөөлөх тухай хэлэлцээр, татвартай холбогдсон бусад гэрээ хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохирогч аль аль Талаас гуравдагч улсуудын иргэд буюу компанид олгодог давуу талд хамаарахгүй.

Дөрөвдүгээр зүйл

1. Хэлэлцэн тохирогч аль аль Талын иргэд буюу компаний хийсэн хөрөнгө оруулалт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт бүрэн хамгаалалт, аюулгүй байдалд байна.

2. Хэлэлцэн тохирогч аль аль Талын иргэд буюу компаний хөрөнгө оруулалтыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт зөвхөн нийгмийн эрх ашгийн үүднээс болон нөхөн төлбөр хийх үндсэн дээр дайчлан гаргуулах буюу улсын өмч болгох, эсхүл дайчлан гаргуулах буюу улсын өмч болгохтой ижил төстэй үр дагавар бүхий бусад арга хэмжээнд хамааруулж болно. Нөхөн төлбөрийн хэмжээ нь тухайн эд хөрөнгийн дайчлан гаргуулах, улсын өмч болгох буюу тэдгээртэй ижил төстэй арга хэмжээнд хамрагдах эсхүл хамрагдаж болзошгүй нь олон нийтэд мэдэгдэхийн өмнөх үеийн үнэ өртөгтэй дүйх болно. Нөхөн төлбөрийг саадгүй хийж гүйцэтгэх бөгөөд түүнийг төлж дуусах хүртэлх

verwertbar und frei transferierbar sein. Die Rechtmäßigkeit der Enteignung, der Verstaatlichung oder der vergleichbaren Maßnahme und die Höhe der Entschädigung müssen in einem ordentlichen Rechtsverfahren nachgeprüft werden können.

(3) Staatsangehörige oder Gesellschaften einer Vertragspartei, die durch Krieg oder sonstige bewaffnete Auseinandersetzungen, Revolution, Staatsnotstand oder Aufruhr im Hoheitsgebiet der anderen Vertragspartei Verluste an Kapitalanlagen erleiden, werden von dieser Vertragspartei hinsichtlich der Rückerstattungen, Abfindungen, Entschädigungen oder sonstigen Gegenleistungen nicht weniger günstig behandelt als ihre eigenen Staatsangehörigen oder Gesellschaften. Solche Zahlungen müssen frei transferierbar sein.

Artikel 5

Jede Vertragspartei gewährleistet den Staatsangehörigen oder Gesellschaften der anderen Vertragspartei den freien Transfer der im Zusammenhang mit einer Kapitalanlage stehenden Zahlungen, insbesondere

- a) des Kapitals und zusätzlicher Beträge zur Aufrechterhaltung oder Ausweitung der Kapitalanlage;
- b) der Erträge;
- c) zur Rückzahlung von Darlehen;
- d) des Erlöses im Fall vollständiger oder teilweiser Liquidation oder Veräußerung der Kapitalanlage;
- e) der in Artikel 4 vorgesehenen Entschädigungen.

Artikel 6

Leistet eine Vertragspartei ihren Staatsangehörigen oder Gesellschaften Zahlungen aufgrund einer Gewährleistung für eine Kapitalanlage im Hoheitsgebiet der anderen Vertragspartei, so erkennt diese andere Vertragspartei, unbeschadet der Rechte der erstgenannten Vertragspartei aus Artikel 10, die Übertragung aller Rechte oder Ansprüche dieser Staatsangehörigen oder Gesellschaften kraft Gesetzes oder aufgrund Rechtsgeschäfts auf die erstgenannte Vertragspartei an. Ferner erkennt die andere Vertragspartei den Eintritt der erstgenannten Vertragspartei in alle diese Rechte oder Ansprüche (übertragene Ansprüche) an, welche die erstgenannte Vertragspartei in demselben Umfang wie ihr Rechtsvorgänger auszuüben berechtigt ist. Für den Transfer von Zahlungen aufgrund der übertragenen Ansprüche gelten Artikel 4 Absätze 2 und 3 und Artikel 5 entsprechend.

Artikel 7

(1) Transferierungen nach Artikel 4 Absatz 2 oder 3, nach Artikel 5 oder nach Artikel 6 erfolgen unverzüglich zu dem jeweils gültigen Kurs.

(2) Dieser Kurs muß dem Kreuzkurs (cross rate) entsprechen, der sich aus denjenigen Umrechnungskursen ergibt, die der Internationale Währungsfonds zum Zeitpunkt der Zahlung Umrechnungen der betreffenden Währungen in Sonderziehungsrechte zugrunde legen würde.

Artikel 8

(1) Ergibt sich aus den Rechtsvorschriften einer Vertragspartei oder aus völkerrechtlichen Verpflichtungen, die neben diesem Vertrag zwischen den Vertragsparteien bestehen oder in Zukunft begründet werden, eine allgemeine oder besondere Regelung, durch die den Kapitalanlagen der Staatsangehörigen oder Gesellschaften der anderen Vertragspartei eine günstigere Behandlung als nach diesem Vertrag zu gewähren ist, so geht diese Regelung dem vorliegenden Vertrag insoweit vor, als sie günstiger ist.

хугацаанд банкны ердийн хүүг нэмж төлнө. Нөхөн төлбөр нь үр ашигтай зарцуулах, чөлөөтэй гуйвуулах боломжтой байна. Дайчлан гаргуулах, улсын өмч болгох эсхүл тэдгээртэй ижил төстэй аль ч арга хэмжээ нь хууль зүйд нийцэж байгаа эсэх, мөн түүнчлэн нөхөн төлбөрийн хэмжээ нь зохистой эсэхийг хууль тогтоомжийн дагуу хянуулах боломжтой байна.

3. Дайн болон бусад зэвсэгт мөргөлдөөн, хувьсгал буюу бослого гарах, эсхүл үндэсний онцгой байдал зарласны улмаас Хэлэлцэн тохирогч аль аль Талын иргэд буюу компаниас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хийсэн хөрөнгө оруулалтад хохирол учрахад хүрвэл Хэлэлцэн тохирогч нөгөө Тал хохирлыг арилгах, түүнээс сэргийлэх, хохирлыг нөхөн төлөх буюу түүний зохицуулалттай холбогдсон бусад арга хэмжээг авахдаа өөрийн иргэд буюу компанид олгодогсоо дутуугүй тааламжтай нөхцөлийг хохирол учирч буй иргэд буюу компанид олгоно. Үүнээс үүдсэн төлбөрийг чөлөөтэй гуйвуулна.

Тавдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Тал бүр хөрөнгө оруулалттай холбогдсон, тухайлбал дараах төлбөрийг чөлөөтэй гуйвуулах баталгааг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэд буюу компанид өгнө. Үүнд:

- a) хөрөнгө оруулалтыг хэвээр байлгах буюу өргөтгөхөд зарцуулсан үндсэн болон нэмэгдэл хөрөнгө;
- b) өгөөж;
- в) зээлийн төлбөр;
- г) хөрөнгө оруулалтыг бүхэлд нь буюу хэсэгчлэн худалдах эсхүл татан буулгаснаас олсон орлого;
- д) дөрөвдүгээр зүйлд дурдсан нөхөн төлбөр зэрэг болно.

Зургадугаар зүйл

Хэлэлцэн тохирогч аль аль Талаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хийсэн хөрөнгө оруулалтад өгсөн баталгааныхаа дагуу өөрийн аль ч иргэд буюу компанид төлбөр төлж байгаа бол Хэлэлцэн тохирогч нөгөө Тал нь эдгээр иргэд буюу компаний аль ч эрх буюу шаардах эрх төлбөр төлж байгаа Хэлэлцэн Тохирогч Талд хууль тогтоомжийн дагуу эсхүл хууль ёсны хэлцлийн дагуу шилжсэнийг хүлээн зөвшөөрөх бөгөөд энэ нь аравдугаар зүйлд дурдсан Хэлэлцэн тохирогч тухайн Талын эрхэд харшлахгүй болно. Түүнчлэн Хэлэлцэн тохирогч тухайн Тал шилжүүлж авсан аль ч эрх буюу шаардах эрхээ (цаашид шилжсэн шаардах эрх гэх) тэдгээрийг залгамжлуулагчийн нэг адил эдлэхийг Хэлэлцэн тохирогч нөгөө тал зөвшөөрнө. Ийнхүү шилжсэн шаардах эрхийн дагуу хийх төлбөрийг гуйвуулахад дөрөвдүгээр зүйлийн 2, 3 дахь заалт, тэрчлэн тавдугаар зүйлийг тус тус баримтална.

Долдугаар зүйл

1. Дөрөвдүгээр зүйлийн 2 буюу 3, тав буюу зургадугаар зүйлд дурдсан гуйвуулгыг тухайн үеийн ханшаар тооцож, саадгүй хийнэ.

2. Энэхүү ханш нь тухайн төлбөрийг хийх үед Олон улсын валютын сангаас тусгай эрхэд хамрагдсан валютыг хөрвүүлэхдээ баримтлах ханшуудтай зохицсон байна.

Наймдугаар зүйл

1. Хэрэв Хэлэлцэн тохирогч аль аль Талын хууль тогтоомжийн заалт эсхүл Хэлэлцэн тохирогч талуудаас олон улсын эрхийн дагуу энэхүү Гэрээнд нэмэлт болгож хүлээх эсвэл цаашид хүлээж болох үүргүүд нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэд буюу компаний хөрөнгө оруулалтад илүү тааламжтай нөхцөл олгосон нийтлэг буюу тодорхой заалттай байвал эдгээр заалтыг энэхүү Гэрээнээс илүү тааламжтай нөхцөл тогтоосон хэсэгт нь дагаж мөрднө.

(2) Jede Vertragspartei wird jede andere Verpflichtung einhalten, die sie in bezug auf Kapitalanlagen von Staatsangehörigen oder Gesellschaften der anderen Vertragspartei in ihrem Hoheitsgebiet übernommen hat.

Artikel 9

Dieser Vertrag gilt auch für noch bestehende Kapitalanlagen, die Staatsangehörige oder Gesellschaften der einen Vertragspartei in Übereinstimmung mit den Rechtsvorschriften der anderen Vertragspartei in deren Hoheitsgebiet schon vor dem Inkrafttreten dieses Vertrags vorgenommen haben.

Artikel 10

(1) Meinungsverschiedenheiten zwischen den Vertragsparteien über die Auslegung oder Anwendung dieses Vertrags sollen, soweit möglich, durch die Regierungen der beiden Vertragsparteien beigelegt werden.

(2) Kann eine Meinungsverschiedenheit auf diese Weise nicht beigelegt werden, so ist sie auf Verlangen einer der beiden Vertragsparteien einem Schiedsgericht zu unterbreiten.

(3) Das Schiedsgericht wird von Fall zu Fall gebildet, indem jede Vertragspartei ein Mitglied bestellt und beide Mitglieder sich auf den Angehörigen eines dritten Staates als Obmann einigen, der von den Regierungen der beiden Vertragsparteien zu bestellen ist. Die Mitglieder sind innerhalb von zwei Monaten, der Obmann innerhalb von drei Monaten zu bestellen, nachdem die eine Vertragspartei der anderen mitgeteilt hat, daß sie die Meinungsverschiedenheit einem Schiedsgericht unterbreiten will.

(4) Werden die in Absatz 3 genannten Fristen nicht eingehalten, so kann in Ermangelung einer anderen Vereinbarung jede Vertragspartei den Präsidenten des Internationalen Gerichtshofs bitten, die erforderlichen Ernennungen vorzunehmen. Besitzt der Präsident die Staatsangehörigkeit einer der beiden Vertragsparteien oder ist er aus einem anderen Grund verhindert, so soll der Vizepräsident die Ernennungen vornehmen. Besitzt auch der Vizepräsident die Staatsangehörigkeit einer der beiden Vertragsparteien oder ist auch er verhindert, so soll das im Rang nächstfolgende Mitglied des Gerichtshofs, das nicht die Staatsangehörigkeit einer der beiden Vertragsparteien besitzt, die Ernennungen vornehmen.

(5) Das Schiedsgericht entscheidet mit Stimmenmehrheit. Seine Entscheidungen sind bindend. Jede Vertragspartei trägt die Kosten ihres Mitglieds sowie ihrer Vertretung in dem Verfahren vor dem Schiedsgericht; die Kosten des Obmanns sowie die sonstigen Kosten werden von den beiden Vertragsparteien zu gleichen Teilen getragen. Das Schiedsgericht kann eine andere Kostenregelung treffen. Im übrigen regelt das Schiedsgericht sein Verfahren selbst.

(6) Sind beide Vertragsparteien auch Vertragsstaaten des Übereinkommens vom 18. März 1965 zur Beilegung von Investitionsstreitigkeiten zwischen Staaten und Angehörigen anderer Staaten, so kann mit Rücksicht auf die Regelung in Artikel 27 Absatz 1 des Übereinkommens das vorstehend vorgesehene Schiedsgericht insoweit nicht angerufen werden, als zwischen dem Staatsangehörigen oder der Gesellschaft einer Vertragspartei und der anderen Vertragspartei eine Vereinbarung nach Maßgabe des Artikels 25 des Übereinkommens zustande gekommen ist. Die Möglichkeit, das vorstehend vorgesehene Schiedsgericht im Fall der Nichtbeachtung einer Entscheidung des Schiedsgerichts des genannten Übereinkommens (Artikel 27) oder im Fall der Übertragung kraft Gesetzes oder aufgrund Rechtsgeschäfts nach Artikel 6 dieses Vertrags anzurufen, bleibt unberührt.

Artikel 11

(1) Meinungsverschiedenheiten in bezug auf Kapitalanlagen zwischen einer der Vertragsparteien und einem Staatsangehörigen oder einer Gesellschaft der anderen Vertragspartei sollen, soweit möglich, zwischen den Streitparteien gütlich beigelegt werden.

2. Хэлэлцэн тохирогч Тал бүр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэд буюу компаниас түүний нутаг дэвсгэрт хийсэн хөрөнгө оруулалттай холбогдуулан хүлээсэн аль ч үүргээ дагаж биелүүлнэ.

Есдүгээр зүйл

Энэхүү Гэрээ нь түүнийг хүчин төгөлдөр болохоос өмнө Хэлэлцэн тохирогч аль аль Талын иргэд буюу компаниас Хэлэлцэн Тохирогч нөгөө талын Нутаг дэвсгэрт түүний хууль тогтоомжийн дагуу хийсэн бөгөөд бэлэн байгаа хөрөнгө оруулалтад нэг адил хамаарна.

Аравдугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч Талуудын хооронд энэхүү Гэрээг тайлбарлах буюу дагаж мөрдөхөөс үүдэн гарсан санал зөрөлдөөнийг Хэлэлцэн тохирогч хоёр Талын Засгийн газрууд аль болох шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

2. Хэрэв санал зөрөлдөөнийг ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол түүнийг Хэлэлцэн тохирогч аль аль Талын хүсэлтээр арбитрын шүүхэд мэдүүлнэ.

3. Арбитрын шүүхийг хэрэг тус бүрээр байгуулна. Ингэхдээ Хэлэлцэн тохирогч Тал бүр шүүхийн нэг нэг гишүүнийг томилох бөгөөд эдгээр хоёр гишүүн нь гуравдагч аливаа орны иргэдээс даргыгаа сонгож, түүнийг Хэлэлцэн тохирогч хоёр Талын Засгийн газар батлан томилно. Хэлэлцэн тохирогч аль аль Тал маргааныг арбитрын шүүхэд оруулах бодолтой байгаагаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа мэдэгдсэнээс хойш шүүхийн гишүүдийг 2 сарын дотор, даргыг 3 сарын дотор томилсон байна.

4. Хэрэв 3 дахь заалтад дурдсан хугацааг баримтлаагүй бөгөөд өөр ямар нэг Тохиролцоонд хүрч чадаагүй бол Хэлэлцэн тохирогч аль аль Тал нь Олон улсын шүүхийн даргад хандаж шаардлагатай томилолт хийхийг хүсч болно. Хэрэв уг дарга Хэлэлцэн тохирогч аль нэг Талын иргэн байх буюу бусад шалтгаанаар дээрх үүргийг гүйцэтгэж чадахгүй бол түүний орлогчоор шаардлагатай томилолтыг хийлгэх ёстой. Харин орлогч дарга Хэлэлцэн тохирогч аль нэг Талын иргэн байх буюу бусад шалтгаанаар уг үүргийг гүйцэтгэж чадахгүй бол Хэлэлцэн тохирогч аль аль Талын иргэн биш бөгөөд Олон улсын шүүхийн удаахь зиндааны гишүүн шаардлагатай томилолтыг хийнэ.

5. Арбитрын шүүхийн шийдвэрийг олонхийн саналаар гаргана. Эдгээр шийдвэрийг заавал биелүүлнэ. Хэлэлцэн тохирогч тал бүр өөрийн сонгосон гишүүний болон арбитрт өөрийгөө төлөөлснийхээ зардлыг хариуцна. Даргын болон үлдэж буй бусад зардлыг Хэлэлцэн тохирогч Талууд тэнцүү хувааж даана. Арбитрын шүүх зардлыг өөр хувиар хуваан хариуцуулж болно. Арбитрын шүүх энд дурдсанаас бусад бүх асуудлаар дэгээ тогтооно.

6. Хэрэв Хэлэлцэн тохирогч хоёр Тал Улс болон бусад улсын иргэдийн хоорондын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай 1965 оны 3 дугаар сарын 18-ны Конвенцийн Хэлэлцэн тохирогч Талууд мөн бөгөөд Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд буюу Компани болон Хэлэлцэн тохирогч нөгөө Тал дурдсан Конвенцийн 25 дугаар зүйлийн дагуу харилцан тохирсон тохиолдолд уг конвенцийн 27 дугаар зүйлийн 1 дэх заалтыг үндэс болгон дээр дурдсан арбитрын шүүхэд хандахгүй байж болно. Гэвч энэ нь дурдсан конвенцийн дагуу байгуулсан арбитрын шүүхийн шийдвэр түүний 27 дугаар зүйлд нийцэхгүй байх эсхүл энэхүү Гэрээний зургадугаар зүйлд дурдсанчлан шаардах эрх хууль тогтоомж эсхүл хууль ёсны хэлцлийн дагуу шилжиж байгаа тохиолдолд дээрх заалтуудад дурдсан арбитрын шүүхэд хандах явдлыг үгүйсгэхгүй.

Арван нэгдүгээр зүйл

1. Хэлэлцэн тохирогч аливаа Тал болон Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэд буюу компанийн хооронд хөрөнгө оруулалтаас үүдэн гарч буй санал зөрөлдөөнийг маргаанд оролцогч талууд нь аль болох эвийн журмаар шийдвэрлэх үүрэгтэй.

(2) Kann die Meinungsverschiedenheit innerhalb einer Frist von sechs Monaten ab dem Zeitpunkt ihrer Geltendmachung durch eine der beiden Streitparteien nicht beigelegt werden, so wird sie auf Verlangen des Staatsangehörigen oder der Gesellschaft der anderen Vertragspartei einem Schiedsverfahren unterworfen. Jede Vertragspartei erklärt hiermit ihr Einverständnis zu einem solchen Schiedsverfahren. Sofern die Streitparteien keine abweichende Vereinbarung treffen, sind die Bestimmungen des Artikels 10 Absätze 3 bis 5 sinngemäß mit der Maßgabe anzuwenden, daß die Bestellung der Mitglieder des Schiedsgerichts nach Artikel 10 Absatz 3 durch die Streitparteien erfolgt und daß, soweit die in Artikel 10 Absatz 3 genannten Fristen nicht eingehalten werden, jede Streitpartei mangels anderer Vereinbarungen den Präsidenten des Schiedsgerichtshofs der Internationalen Handelskammer in Paris bitten kann, die erforderlichen Ernennungen vorzunehmen. Der Schiedsspruch wird nach innerstaatlichem Recht vollstreckt.

(3) Die an der Streitigkeit beteiligte Vertragspartei wird während eines Schiedsverfahrens oder der Vollstreckung eines Schiedsspruchs nicht als Einwand geltend machen, daß der Staatsangehörige oder die Gesellschaft der anderen Vertragspartei eine Entschädigung für einen Teil des Schadens oder den Gesamtschaden aus einer Versicherung erhalten hat.

(4) Für den Fall, daß beide Vertragsparteien auch Vertragsstaaten des Übereinkommens vom 18. März 1965 zur Beilegung von Investitionsstreitigkeiten zwischen Staaten und Angehörigen anderer Staaten geworden sind, werden Meinungsverschiedenheiten nach diesem Artikel zwischen den Streitparteien einem Schiedsverfahren im Rahmen des vorgenannten Übereinkommens unterworfen, es sei denn, die Streitparteien treffen eine abweichende Vereinbarung; jede Vertragspartei erklärt hiermit ihr Einverständnis zu einem solchen Verfahren.

Artikel 12

Dieser Vertrag gilt unabhängig davon, ob zwischen den beiden Vertragsparteien diplomatische oder konsularische Beziehungen bestehen.

Artikel 13

(1) Dieser Vertrag bedarf der Ratifikation; die Ratifikationsurkunden werden so bald wie möglich in Ulan Bator ausgetauscht.

(2) Dieser Vertrag tritt einen Monat nach Austausch der Ratifikationsurkunden in Kraft. Er bleibt zehn Jahre lang in Kraft; nach deren Ablauf verlängert sich die Geltungsdauer auf unbegrenzte Zeit, sofern nicht eine der beiden Vertragsparteien den Vertrag mit einer Frist von zwölf Monaten vor Ablauf schriftlich kündigt. Nach Ablauf von zehn Jahren kann der Vertrag jederzeit mit einer Frist von zwölf Monaten gekündigt werden.

(3) Für Kapitalanlagen, die bis zum Zeitpunkt des Außerkrafttretens dieses Vertrags vorgenommen worden sind, gelten die Artikel 1 bis 12 noch für weitere zwanzig Jahre vom Tag des Außerkrafttretens des Vertrags an.

Geschehen zu Bonn am 26. Juni 1991 in zwei Urschriften, jede in deutscher und mongolischer Sprache, wobei jeder Wortlaut gleichermaßen verbindlich ist.

Für die Bundesrepublik Deutschland
Холбооны Бүгд Найрамдах Герман Улсыг Төлөөлж
Genscher

Für die Mongolische Volksrepublik
Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг Төлөөлж
Gombosuren

2. Хэрэв санал зөрөлдөөнийг түүнд оролцогч аль нэг тал хөндөж тавьснаас хойш 6 сарын хугацаанд шийдвэрлэж чадаагүй бол түүнийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэд буюу компаний хүсэлтээр арбитрын журмаар шийдвэрлүүлнэ. Хэлэлцэн тохирогч Тал бүр арбитрын журмыг хүлээн зөвшөөрснөө үүгээр тунхаглаж байна. Маргаанд оролцогч талууд өөрөөр тохиролцоогүйгээс бусад тохиолдолд аравдугаар зүйлийн 3-5 дахь заалтыг тус тус баримтална. Тэгэхдээ маргаанд оролцогч талууд арбитрын шүүхийн гишүүдийг аравдугаар зүйлийн 3 дахь заалтын дагуу томилох бөгөөд аравдугаар зүйлийн 3 дахь заалтад дурдсан хугацааг баримтлаагүй хийгээд бусад тохиролцоонд хүрээгүй нөхцөлд шаардлагатай томилолт хийхийг Парис дахь Олон улсын худалдааны танхимын дэргэдэх Олон улсын арбитрын шүүхийн даргаас хүснэ. Арбитрын шийдвэрийг дотоодын хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ.

3. Маргаанд оролцож буй Хэлэлцэн тохирогч тал нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэд буюу компани учирсан хохирлоо даатгалын контрактын үндсэн дээр бүрэн буюу хагас нөхөн төлүүлсэн гэдэг шалтгаанаар арбитрын хурлын үлээр буюу түүний шийдвэрийг гүйцэтгэх явцад эсэргүүцэл илэрхийлж болохгүй.

4. Хэлэлцэн тохирогч Талууд Улс болон бусад улсын иргэдийн хоорондын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай 1965 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн Конвенцийн Хэлэлцэн тохирогч Талууд болсон тохиолдолд маргаанд оролцогч талуудын хооронд энэ зүйлийн дагуу гарсан санал зөрөлдөөнийг Хэлэлцэн тохирогч Талууд өөрөөр тохиролцоогүйгээс бусад тохиолдолд дээр дурдсан конвенцийн дагуу арбитрт мэдүүлнэ. Хэлэлцэн тохирогч Тал бүр уг дэгийг хүлээн зөвшөөрснөө үүгээр нотолж байна.

Арван хоёрдугаар зүйл

Энэхүү Гэрээ нь Хэлэлцэн тохирогч Талуудын хооронд дипломат буюу консулын харилцаа байгаа эсэхийг үл харгалзан хүчин төгөлдөр хэвээр байна.

Арван гуравдугаар зүйл

1. Энэхүү гэрээг соёрхон батална. Батламж жуух бичгийг аль болох ойрын хугацаанд Улаанбаатар хотноо солилцоно.

2. Энэхүү гэрээ батламж жуух бичиг солилцоноос хойш нэг сарын дараа хүчин төгөлдөр болно. Энэхүү Гэрээ нь 10 жилийн хугацаанд хүчинтэй байх бөгөөд Хэлэлцэн тохирогч аль нэг Тал түүнийг цуцлах тухайгаа 12 сарын өмнө бичгээр мэдэгдээгүй бол цаашид тодорхой бус хугацаагаар хүчин төгөлдөр хэвээр байна. 10 жилийн хугацаа өнгөрсөн нөхцөлд Хэлэлцэн тохирогч аль аль Тал 12 сарын өмнө бичгээр мэдэгдэх замаар хэдийд ч энэхүү Гэрээг цуцалж болно.

3. Энэхүү Гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд хийсэн хөрөнгө оруулалтын хувьд түүний I-12 дугаар зүйлийн заалтуудыг энэхүү Гэрээ хүчин төгөлдөр бус болсон өдрөөс хойш 20 жилийн турш дагаж мөрдөнө.

1991 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Бонн хотноо герман, монгол хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх хувиуд нь адил хүчинтэй байна.

Protokoll

Протокол

Bei der Unterzeichnung des Vertrags zwischen der Bundesrepublik Deutschland und der Mongolischen Volksrepublik über die Förderung und den gegenseitigen Schutz von Kapitalanlagen haben die unterzeichneten Bevollmächtigten außerdem folgende Bestimmungen vereinbart, die als Bestandteil des Vertrags gelten:

(1) Zu Artikel 1

- a) Erträge aus der Kapitalanlage und im Fall ihrer Wiederanlage auch deren Erträge genießen den gleichen Schutz wie die Kapitalanlage.
- b) Unbeschadet anderer Verfahren zur Feststellung der Staatsangehörigkeit gilt insbesondere als Staatsangehöriger einer Vertragspartei jede Person, die einen von den zuständigen Behörden der betreffenden Vertragspartei ausgestellten nationalen Reisepaß besitzt.

(2) Zu Artikel 2

Der Vertrag gilt auch in den Gebieten der ausschließlichen Wirtschaftszone und des Festlandsockels, soweit das Völkerrecht der jeweiligen Vertragspartei die Ausübung von souveränen Rechten oder Hoheitsbefugnissen in diesen Gebieten erlaubt.

(3) Zu Artikel 3

- a) Als „Betätigung“ im Sinne des Artikels 3 Absatz 2 ist insbesondere, aber nicht ausschließlich, die Verwaltung, die Verwendung, der Gebrauch und die Nutzung einer Kapitalanlage anzusehen. Als eine „weniger günstige“ Behandlung im Sinne des Artikels 3 ist insbesondere anzusehen: die Einschränkung des Bezugs von Roh- und Hilfsstoffen, Energie und Brennstoffen sowie Produktions- und Betriebsmitteln aller Art, die Behinderung des Absatzes von Erzeugnissen im In- und Ausland sowie sonstige Maßnahmen mit ähnlicher Auswirkung. Maßnahmen, die aus Gründen der öffentlichen Sicherheit und Ordnung, der Volksgesundheit oder Sittlichkeit zu treffen sind, gelten nicht als „weniger günstige“ Behandlung im Sinne des Artikels 3.
- b) Die Bestimmungen des Artikels 3 verpflichten eine Vertragspartei nicht, steuerliche Vergünstigungen, Befreiungen und Ermäßigungen, welche gemäß den Steuergesetzen nur den in ihrem Hoheitsgebiet ansässigen natürlichen Personen und Gesellschaften gewährt werden, auf im Hoheitsgebiet der anderen Vertragspartei ansässige natürliche Personen und Gesellschaften auszudehnen.
- c) Die Vertragsparteien werden im Rahmen ihrer innerstaatlichen Rechtsvorschriften Anträge auf die Einreise und den Aufenthalt von Personen der einen Vertragspartei, die im Zusammenhang mit einer Kapitalanlage in das Hoheitsgebiet der anderen Vertragspartei einreisen wollen, wohlwollend prüfen; das gleiche gilt für Arbeitnehmer der einen Vertragspartei, die im Zusammenhang mit einer Kapitalanlage in das Hoheitsgebiet der anderen Vertragspartei einreisen und sich dort aufhalten wollen, um eine Tätigkeit als Arbeitnehmer auszuüben. Auch Anträge auf Erteilung der Arbeitserlaubnis werden wohlwollend geprüft.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хоорондын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Гэрээнд гарын үсэг зурж буй бүрэн эрхт төлөөлөгчид нь дурдсан Гэрээний салшгүй хэсэг болох дараах тодотгол заалтуудыг нэмж тохиролцов. Үүнд:

1. Нэгдүгээр зүйлд

- a) Хөрөнгө оруулалтын өгөөж болон эдгээр өгөөжөөр дахин хөрөнгө оруулалт хийж байгаа тохиолдолд тэдгээрийн өгөөж нь хөрөнгө оруулалтын нэг адил хамгаалалтад байна.
- b) Холбогдох Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллагаас олгосон үндэсний паспорт эзэмшигчийг тухайн Талын иргэн гэж үзэх боловч энэ нь үндэсний харьяаллыг тодорхойлох бусад аль ч арга замыг үгүйсгээгүй болно.

2. Хоёрдугаар зүйлд

Энэхүү Гэрээ нь холбогдох Хэлэлцэн тохирогч Талаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхийг нь олон улсын эрхээр зөвшөөрсөн далай тэнгис дэх эдийн засгийн онцгой бүс нутаг болон эх газрын дагуух бүс нутагт нэг адил хамаарна.

3. Гуравдугаар зүйлд

- a) Гуравдугаар зүйлийн 2 дахь заалтад дурдсан „үйл ажиллагаа“ гэсэн нэр томъёогоор хэдий зөвхөн дараах зүйлээр хязгаарлахгүй боловч, тухайлбал хөрөнгө оруулалтыг удирдах, ашиглах, эзэмших, хөрөнгө оруулалттай байх явдлыг хэлнэ. Гуравдугаар зүйлд дурдсан „дутуугүй тааламжтай нөхцөл“ гэсэн нэр томъёогоор тухайлбал түүхий эд буюу туслах материал, түлш эрчим хүч, мөн түүнчлэн үйлдвэрлэлийн буюу бусад аль ч зориулалтын хэрэгсэл олж авахад нь хязгаар тавих, тухайн оронд буюу хилийн чанад бүтээгдэхүүнээ борлуулахад нь саад тотгор учруулах, тэдгээртэй ижил төстэй бусад арга хэмжээ авахгүй байхыг хэлнэ. Улсын аюулгүй байдал, нийгмийн хэв журам, иргэдийн эрүүл мэнд буюу ёс суртахууныг хамгаалах зорилгоор авч буй арга хэмжээг гуравдугаар зүйлд дурдсан „дутуугүй тааламжтай нөхцөл“ – д хамруулахгүй.
- b) Хэлэлцэн тохирогч аливаа Тал нь түүний хууль тогтоомжийн дагуу зөвхөн тухайн Талын нутаг дэвсгэрт оршдог бие хүн буюу компанид хамруулдаг татвар, татвараас чөлөөлөх буюу татварын хэмжээг хорогдуулах зэрэг хөнгөлөлтийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршдог хувь хүн буюу компанид хамруулах үүргийг гуравдугаар зүйлийн заалтуудаар хүлээгээгүй болно.
- b) Хэлэлцэн тохирогч Талууд нь хөрөнгө оруулалттай холбогдсон асуудлаар Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт орох, тэнд түр хугацаагаар байх тухай Хэлэлцэн тохирогч аль аль Талын хүмүүсийн хүсэлтүүдэд өөрсдийн хууль тогтоомжийн хүрээнд нааштай хандах болно. Хөрөнгө оруулалттай холбогдсон ажилд орохоор Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт орох, тэнд түр байх хүсэлтэй Хэлэлцэн тохирогч аль аль Талын хүмүүст мөн нэг адил хандана. Түүнчлэн ажил эрхлэх зөвшөөрөл авах тухай хүсэлтүүдийг нааштай авч үзнэ.

(4) Zu Artikel 4

Ein Anspruch auf Entschädigung besteht auch dann, wenn durch staatliche Maßnahmen in das Unternehmen, das Gegenstand der Kapitalanlage ist, eingegriffen und dadurch seine wirtschaftliche Substanz erheblich beeinträchtigt wird.

(5) Zu Artikel 7

Als „unverzüglich“ durchgeführt im Sinne des Artikels 7 Absatz 1 gilt ein Transfer, der innerhalb einer Frist erfolgt, die normalerweise zur Beachtung der Transferförmlichkeiten erforderlich ist. Die Frist beginnt mit der Einreichung eines vollständigen und formgerechten Antrags und darf unter keinen Umständen zwei Monate überschreiten.

(6) Bei Beförderung von Gütern und Personen, die im Zusammenhang mit einer Kapitalanlage stehen, wird eine Vertragspartei die Transportunternehmen der anderen Vertragspartei weder ausschalten noch behindern und, soweit erforderlich, Genehmigungen zur Durchführung der Transporte erteilen. Hierunter fallen Beförderungen von

- a) Gütern, die unmittelbar für die Kapitalanlage im Sinne des Vertrags bestimmt sind oder die im Hoheitsgebiet einer Vertragspartei oder eines dritten Staates von einem Unternehmen oder im Auftrag eines Unternehmens angeschafft werden, in dem Vermögenswerte im Sinne des Vertrags angelegt sind;
- b) Personen, die im Zusammenhang mit einer Kapitalanlage reisen.

Geschehen zu Bonn am 26. Juni 1991 in zwei Urschriften, jede in deutscher und mongolischer Sprache, wobei jeder Wortlaut gleichermaßen verbindlich ist.

4. Дөрөвдүгээр зүйлд

Хөрөнгө оруулалт хийсэн компаний үйл ажиллагаанд улсын зүгээс хэт оролцсоны улмаас эдийн засгийн үзүүлэлтэд нь хохирол учирвал нөхөн төлбөр хийхийг нэг адил шаардах эрхтэй байна.

5. Долдугаар зүйлд

Гуйвуулгыг ердийн нөхцөлд хийхэд шаардагддаг хугацаанд хийж гүйцэтгэсэн байвал түүнийг долдугаар зүйлийн 1 дэх заалтад дурдсанчлан „саадгүй“ хийж гүйцэтгэсэн гэж үзнэ. Дурдсан хугацаа нь зохих хэлбэрээр бүрэн бүрдүүлсэн хүсэлт гаргасан өдөр эхлэх бөгөөд аль ч тохиолдолд хоёр сараас хэтрэхгүй байна.

6. Хэлэлцэн тохирогч Тал бүр хөрөнгө оруулалттай холбогдсон бараа буюу хумуусийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын тээврийн байгууллагаас тээвэрлэхэд ямар ч саад тогтор учруулахгүй бөгөөд шаардлагатай бол тухайн тээврийг хийх зөвшөөрлийг олгож байна. Үүнд дараах зүйлийн тээвэрлэлт хамаарна:

- a) Энэхүү Гэрээний агуулгын дагуу үнэ өртөг бүхий зүйлээр хөрөнгө оруулалт хийсэн байгууллага буюу түүний нэрийн өмнөөс Хэлэлцэн тохирогч аль аль Тал эсвэл гуравдагч аливаа улсын нутаг дэвсгэрт олж авсан эсхүл энэхүү Гэрээний дагуу хөрөнгө оруулалт хийхтэй шууд холбогдсон бараа;
- б) хөрөнгө оруулалттай холбогдсон асуудлаар зорчиж буй хүмүүс зэрэг болно.

1991 оны 6 дугаар сарын „26“-ны өдөр Бонн хотноо герман, монгол хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх хувиуд нь адил хүчинтэй байна.

Für die Bundesrepublik Deutschland
Холбооны Бүгд Найрамдах Герман Улсыг Төлөөлж
Genscher

Für die Mongolische Volksrepublik
Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг Төлөөлж
Gombosuren